



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа	15
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	768,295,603.81	3,126,592,112.95
33	АВЛАГА	00.00	2,323,426,007.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	2,323,426,007.00
35	БАРАА МАТЕРИАЛ	768,295,603.81	803,166,105.95
351	Түүхий эд материал	358,939,287.63	340,872,945.57
35130	Эм боох материал	358,939,287.63	340,872,945.57
354	Хангамжийн материал	409,356,316.18	462,293,160.38
35410	Бичиг хэргийн материал	5,222,935.00	5,402,280.00
35420	Аж ахуйн материал	379,683,892.92	445,551,531.92
35430	Сэлбэг хэрэгсэл	910,000.00	960,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,058,000.00	2,742,400.00
35450	Барилгын засварын материал	11,671,680.00	1,316,500.00
35460	Хүнсний материал	7,809,808.26	6,320,448.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,559,227,577.26	11,879,288,715.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,559,227,577.26	11,879,288,715.43
392	Биет хөрөнгө	6,189,227,577.26	11,509,288,715.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,953,134,108.92	5,448,134,108.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-109,414,063.41	-144,738,434.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	250,963,516.00	161,676,395.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-163,171,849.42	-47,168,333.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,506,565,967.86	8,332,895,377.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,287,590,440.95	-2,297,389,599.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	143,761,068.72	97,922,810.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,934,900.56	-59,647,911.86
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,317,248.40	21,317,248.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,403,078.30	-3,712,945.90
393	Биет бус хөрөнгө	370,000,000.00	370,000,000.00
39301	Програм хангамж	1,030,000.00	1,030,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,030,000.00	-1,030,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	370,000,000.00	370,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,327,523,181.07	15,005,880,828.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	433,184,050.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	433,184,050.00
413	Өглөг	00.00	433,184,050.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	426,369,004.00
4136	Бусад өглөг	00.00	6,815,046.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	806,696.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	6,008,350.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,327,523,181.07	14,572,696,778.38
51	Засгийн газрын хувь оролцоо	7,327,523,181.07	14,572,696,778.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,539,054,700.00	4,539,054,700.00
51101	Өмч: - төрийн	4,539,054,700.00	4,539,054,700.00
512	Хуримтлагдсан үр дүн	-734,459,557.13	6,531,685,947.26
51210	Өмнөх үеийн үр дүн	-734,459,557.13	-713,487,650.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,245,173,597.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,522,928,038.20	3,501,956,131.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,327,523,181.07	15,005,880,828.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,039,931,499.69	20,230,138,778.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	531,355,646.69	7,529,908,994.64
120	Нийтлэг татварын бус орлого	531,355,646.69	7,529,908,994.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,925,547.00	172,801,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,925,547.00	172,801,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,508,575,853.00	12,700,229,784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,945,839.00	605,136,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,364,000.00	141,227,450.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	665,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	515,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,483,757,114.00	11,430,093,534.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,483,757,114.00	11,430,093,534.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,694,665,350.45	12,984,965,181.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,694,665,350.45	12,984,965,181.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,672,263,649.08	12,521,565,181.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,947,598,187.00	5,514,806,914.00
210101	Үндсэн цалин	2,676,262,900.00	2,764,973,002.00
210102	Нэмэгдэл	1,642,591,887.00	2,193,723,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	227,304,000.00	226,176,532.00
210104	Урамшуулал	401,439,400.00	329,933,964.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	622,440,548.45	719,950,655.99
210201	Тэтгэврийн даатгал	436,561,897.45	504,493,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	46,469,488.00	54,806,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	37,175,630.00	43,899,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,293,958.00	10,961,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	92,939,575.00	105,789,855.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	848,930,363.00	995,434,388.27
210301	Гэрэл, цахилгаан	79,286,891.00	90,168,883.27
210302	Түлш, халаалт	591,142,128.00	608,544,752.00
210303	Цэвэр, бохир ус	178,501,344.00	296,720,753.00
2104	Хангамж, бараа материалын зардал	127,827,639.04	143,036,908.00
210401	Бичиг хэрэг	7,574,016.00	11,801,530.00
210402	Тээвэр, шатахуун	61,704,500.00	85,130,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,727,761.00	1,405,985.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,491,255.00	44,698,993.00
2105	Нормативт зардал	1,579,430,877.82	4,287,814,519.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,399,353,513.16	3,986,839,228.26
210502	Хоол, хүнс	180,077,364.66	300,975,291.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,039,290.00	72,092,441.94
210604	Урсгал засвар	29,979,290.00	72,092,441.94
2107	Томилолт, зочны зардал	13,500,000.00	6,439,000.00
210702	Дотоод албан томилолт	13,500,000.00	6,439,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,509,936.00	39,624,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,179,700.00	1,368,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	567,636.00	578,088.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	286,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,582,500.00	17,851,113.00
210807	Газрын төлбөр	1,110,000.00	984,932.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,251,100.00	18,555,042.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	469,986,807.77	742,366,253.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	469,986,807.77	742,366,253.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,401,701.37	463,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,560,000.00	463,400,000.00

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	463,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,560,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,841,701.37	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,841,701.37	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	345,266,149.24	7,245,173,597.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	345,266,149.24	7,245,173,597.31

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,539,054,700.00	3,522,928,038.20	-734,459,557.13	7,327,523,181.07
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,539,054,700.00	3,522,928,038.20	-734,459,557.13	7,327,523,181.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	20,971,907.08	20,971,907.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,539,054,700.00	3,522,928,038.20	-713,487,650.05	7,348,495,088.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-20,971,907.08	00.00	-20,971,907.08
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,245,173,597.31	7,245,173,597.31
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,539,054,700.00	3,501,956,131.12	6,531,685,947.26	14,572,696,778.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,664,501,400.00	10,549,605,727.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,925,547.00	172,801,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,925,547.00	172,801,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,925,547.00	172,801,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,925,547.00	172,801,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,508,575,853.00	10,376,803,777.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,941,872,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,941,872,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,945,839.00	605,136,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,581,839.00	463,908,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,364,000.00	141,227,450.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	665,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	515,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,483,757,114.00	9,106,667,527.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,483,757,114.00	9,106,667,527.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,367,686,300.00	10,493,912,427.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,367,686,300.00	10,493,912,427.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,345,284,598.63	10,030,512,427.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,947,598,187.00	5,514,806,914.00
210101	Үндсэн цалин	2,676,262,900.00	2,764,973,002.00
210102	Нэмэгдэл	1,642,591,887.00	2,193,723,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	227,304,000.00	226,176,532.00
210104	Урамшуулал	401,439,400.00	329,933,964.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	622,440,548.45	719,950,655.99
210201	Тэтгэврийн даатгал	436,561,897.45	504,493,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	46,469,488.00	54,806,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	37,175,630.00	43,899,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,293,958.00	10,961,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	92,939,575.00	105,789,855.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	848,930,363.00	995,434,388.27
210301	Гэрэл, цахилгаан	79,286,891.00	90,168,883.27
210302	Түлш, халаалт	591,142,128.00	608,544,752.00
210303	Цэвэр, бохир ус	178,501,344.00	296,720,753.00
2104	Хангамж, бараа материалын зардал	128,317,371.00	183,938,085.00
210401	Бичиг хэрэг	8,709,500.00	12,126,000.00
210402	Тээвэр, шатахуун	65,249,000.00	82,814,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,856,761.00	1,405,985.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,600,000.00	45,781,910.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,902,110.00	41,809,390.00
2105	Нормативт зардал	1,707,731,623.18	2,509,402,563.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,502,601,230.98	2,212,559,878.00
210502	Хоол, хунс	175,964,992.20	292,663,385.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,165,400.00	4,179,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,323,170.00	60,975,261.94
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	460,400.00	00.00
210604	Урсгал засвар	38,802,770.00	60,975,261.94
2107	Томилолт, зочны зардал	13,500,000.00	6,439,000.00
210702	Дотоод албан томилолт	13,500,000.00	6,439,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,443,336.00	39,565,558.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	1,179,700.00	1,368,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	567,636.00	578,088.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	319,000.00	286,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,821,500.00	17,851,113.00
210807	Газрын төлбөр	1,110,000.00	984,932.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,945,500.00	18,496,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,401,701.37	463,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,560,000.00	463,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	463,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,560,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,841,701.37	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,841,701.37	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>296,815,100.00</u>	<u>55,693,300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	296,815,100.00	55,693,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	296,815,100.00	55,693,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	296,815,100.00	55,693,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	296,815,100.00	55,693,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-296,815,100.00</u>	<u>-55,693,300.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,807,427,900.00	9,944,469,477.00	862,958,423.0	92.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,807,427,900.00	9,944,469,477.00	862,958,423.0	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,800,867,900.00	9,944,469,477.00	856,398,423.0	92.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,606,740,300.00	5,514,806,914.00	91,933,386.0	98.4
210101	Үндсэн цалин	2,790,920,200.00	2,764,973,002.00	25,947,198.0	99.1
210102	Нэмэгдэл	2,224,159,100.00	2,193,723,416.00	30,435,684.0	98.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	230,769,000.00	226,176,532.00	4,592,468.0	98.0
210104	Урамшуулал	360,892,000.00	329,933,964.00	30,958,036.0	91.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	720,243,400.00	719,950,655.99	292,744.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	504,493,200.00	504,493,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	54,806,800.00	54,806,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,899,500.00	43,899,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	10,961,300.00	10,961,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	106,082,600.00	105,789,855.99	292,744.0	99.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,012,780,162.00	995,434,388.27	17,345,773.7	98.3
210301	Гэрэл, цахилгаан	105,864,700.00	90,168,883.27	15,695,816.7	85.2
210302	Түлш, халаалт	608,544,752.00	608,544,752.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	298,370,710.00	296,720,753.00	1,649,957.0	99.4
2104	Хангамж, бараа материалын зардал	174,311,400.00	166,333,885.00	7,977,515.0	95.4
210401	Бичиг хэрэг	14,641,400.00	12,126,000.00	2,515,400.0	82.8
210402	Тээвэр, шатахуун	82,306,000.00	82,306,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,272,300.00	1,405,985.00	2,866,315.0	32.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	46,743,000.00	45,781,910.00	961,090.0	97.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,348,700.00	24,713,990.00	1,634,710.0	93.8
2105	Нормативт зардал	3,155,684,285.00	2,439,578,263.80	716,106,021.2	77.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,822,340,145.00	2,145,039,878.00	677,300,267.0	76.0
210502	Хоол, хүнс	298,771,740.00	292,663,385.80	6,108,354.2	98.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	34,572,400.00	1,875,000.00	32,697,400.0	5.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,239,815.00	62,360,811.94	12,879,003.1	82.9

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	33,878,500.00	21,459,900.00	12,418,600.0	63.3
210604	Урсгал засвар	40,900,915.00	40,900,911.94	3.1	100.0
2107	Томилолт, зочны зардал	14,042,000.00	6,439,000.00	7,603,000.0	45.9
210702	Дотоод албан томилолт	14,042,000.00	6,439,000.00	7,603,000.0	45.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,826,538.00	39,565,558.00	2,260,980.0	94.6
210803	Даатгалын үйлчилгээ	1,368,925.00	1,368,925.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,100,000.00	578,088.00	521,912.0	52.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	286,000.00	114,000.0	71.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,851,113.00	17,851,113.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,110,000.00	984,932.00	125,068.0	88.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,496,500.00	18,496,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6560000.00	1.00	6,559,999.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,560,000.00	01.00	6,559,999.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,560,000.00	01.00	6,559,999.0	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,807,427,900.00	9,944,469,477.00	862,958,423.0	92.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,700,024,700.00	9,106,667,527.00	1,593,357,173.0	85.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,700,024,700.00	9,106,667,527.00	1,593,357,173.0	85.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	107,403,200.00	172,801,950.00	(65,398,750.0)	160.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	107,403,200.00	172,801,950.00	(65,398,750.0)	160.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	331.00	331.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	232.00	232.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	98.00	98.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	331.00	331.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	246.00	246.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	85.00	85.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,136,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,136,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,736,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,604,200.00
210402	Тээвэр, шатахуун	508,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,095,400.00
2105	Нормативт зардал	69,824,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,304,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,307,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,233,400.00
210604	Урсгал засвар	20,074,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463400000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	463,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	463,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605136250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	605,136,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	463,908,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	141,227,450.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах”, 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх”, 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Бид өндөр чадамж, ёс зүй, хариуцлагад суурилсан тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй тэгш үзүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/585 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”

- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй тул үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 10,807.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 108.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 75.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 7,678.4 сая төгрөгөөр буюу 104.8 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өртөлбөрийн дансууд байна. Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	-	2,323.4	2,323.4	-
Бараа материал	768.3	803.2	34.9	4.5

Үндсэн хөрөнгө	6,559.2	11,879.3	5,320.1	81.1
Нийт хөрөнгө	7,327.5	15,005.9	7,678.4	104.8
Өр төлбөр	-	433.2	433.2	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,327.5	14,572.7	7,245.2	98.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,327.5	15,005.9	7,678.4	104.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 2,323.4 сая төгрөг байна.

Авлагын данс нь тайлант жилд эрүүл мэндийн даатгалын санд 11,289.2 сая төгрөгийн даатгуулагчийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэхийг хүргүүлснээс 8,965.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 2,323.4 сая төгрөгийн дутуу санхүүжилтээр авлага үүссэн байна.

- Бараа материалын үлдэгдэл 4.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 34.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,178.4 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 1,350.4 сая төгрөг нийт 4,528.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 4,493.8 сая төгрөгийн зарцуулалт гарч, 803.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 81.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 6,559.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 55.7 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5,028.8 сая төгрөг, үлдэгдэл өртөггүй, элэгдэлээ бүрэн нөхсөн хөрөнгийн дахин үнэлж 977.9 нийт 6,062.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 742.4 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 11,879.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөрийн үлдэгдэл 433.2 сая төгрөг байна.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу санхүүжилт олгосонтой холбоотойгоор 28 ААН, 2 иргэнтэй холбоотой 433.2 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 7,245.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт - /Нийгмийн даатгалын сангаас/	3,483.76	11,430.09	7,946.34
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/	4,941.87	-	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	82.95	605.14	522.19
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	264.03	6,006.73	5,742.70
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	111.40	1,350.37	1,238.98
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155.93	172.80	16.88
Дээд шатны төсөв захирагчаас	-	665.00	665.00
Үйл ажиллагааны орлого	9,039.93	20,230.14	11,190.21
Цалин, шимтгэлийн зардал	5,570.04	6,234.76	664.72
Бусад бараа үйлчилгээний зардал	3,102.22	6,286.81	3,184.59
Урсгал шилжүүлэг	22.40	463.40	441.00
Үйл ажиллагааны зардал	8,694.66	12,984.97	4,290.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	345.27	7,245.17	6,899.91

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 7,946.3 сая төгрөгөөр буюу 3 дахин өссөн нь ковид 19 холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгч, дархлаажуулалт, Пи си ар (PCR)-ын зөөвөр, урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн цогц үйлчилгээ авагч даатгуулагчийн тусламж үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 11,063.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 256.4 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 10,807.4 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 10,807.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр 92 хувь буюу 9,944.5 сая төгрөгийн санхүүжилт авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 862.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Мөн тус байгууллага нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор 2,323.4 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМГ-аас 463.9 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас 121.2 сая төгрөг, аймгийн ОБГ-аас 20.0 сая төгрөг нийт 605.1 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд ковид 19 цар тахалтай холбоотой шинэ эмнэлэг дэлгэж тусгаарлах байрны зардалд аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлсэн 121.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн Онцгой байдлын газраас Пи си ар (PCR)-ын урвалж оношлуур худалдан авахад 20.0 сая төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ЭМГ-аас Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/496, А/585 тушаалын дагуу нэгдсэн эмнэлгийн 331 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зориулж 463.4 сая төгрөгийг мөн сүрьеэгийн сорьц хүргэх шатахууны зардалд 0.5 сая төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор 30216 иргэнд Пи си ар (PCR)-ын шинжилгээг, 870 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 3211 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 2206 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 36503 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Тайлант жилд Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны Б/06 дугаар тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Оюунтүвшинг 2021 оны 01 дүгээр сард томилсон байна.

Мөн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны Б/22 дугаар тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн газрын даргын албан үүргийг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Д.Энх-Амарт хавсруулан гүйцэтгүүлэхээр 2021 оны 10 дугаар сард томилсон байгаа нь тайлангийн жилд төсөв захирагч нар тогтворгүй байсан асуудал ажиглагдлаа.

Төрийн албаны зөвлөлийн Архангай дахь салбар зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 12 дугаар тогтоол, Авилгатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05/322 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн газрын даргын албан тушаалд Т.Ганбямбыг томилсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 80 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 10,807.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 92 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор иргэн, ААН-ээс 9.7 сая төгрөгийн аж ахуйн материалыг хандиваар, Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрөөс 1,505.4 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж хандиваар авсныг бүртгэл тайланд тусгасан байна.
2. Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 10 тээврийн хэрэгсэлд 81.8 сая төгрөгийн шатахуун, 2.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 8 жолоочтой, жолоочийн цалинд 114.3 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нийт 15,039.4 сая төгрөгийн 168 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 15,039.4 сая төгрөгийн 165 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй, 2,893.6 сая төгрөгийн 867 ширхэг хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, тухайн хөрөнгүүдийг холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авч ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,704.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 944.6 сая төгрөгийн алдааг залруулж, 3,759.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө. Залруулагдаагүй 2 алдаа нь материаллаг бус тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг тулган шалгахад үндсэн хөрөнгийн нэмэгдлийг 22.2 сая төгрөгөөр, авлагыг үлдэгдлийг 922.4 сая төгрөгөөр нийт 944.6 сая төгрөгийг дутуу тусгаж тайлагнасанг аудитын явцад залруулга хийлгэлээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой 2,323.4 сая төгрөгийн авлага, 28 ААН, 2 иргэнтэй холбоотой 433.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын дагуу Өр, авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 241 нэр төрлийн 1,002.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oO-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой 2,323.4 сая төгрөгийн авлага, 28 ААН, 2 иргэнтэй холбоотой 433.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	2,756.6							1	2,756.6
2		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 241 нэр төрлийн 1,002.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй	1	1,002.9							1	1,002.9
3		Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг тулган шалгахад үндсэн хөрөнгийн нэмэгдлийг 22.2 сая төгрөгөөр, авлагыг үлдэгдлийг 922.4 сая төгрөгөөр нийт 944.6 сая төгрөгийг дутуу тусгаж тайлагнасан	1	944.6	1	944.6						
Дүн			3	4,704.1	1	944.6					2	3,759.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1								1	
Дүн			1								1	
Нийт дүн			4	4,704.1	1	944.6					3	3,759.5